

**ТӨСВИЙН ШУУД ЗАХИРАГЧИЙН
2019 ОНЫ САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛД
ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ**

Агуулга

1. Аудитын гэрчилгээ	2
2. Аудитын тайлан.....	4
2.1. Оршил	4
2.2. Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага	4
2.3. Аудитад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт	4
2.4. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин	5
2.8. Санхүүгийн тайлангийн үзүүлэлтүүд	6
2.9. Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга.....	7
2.10. Аудитаар хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн.....	7
2.11. Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал	7
2.12. Шилэн дансны мэдээлэл.....	7
2.13. Өмнөх аудитаар өгсөн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт	8
2.14. Дүгнэлтийн хэлбэр, үндэслэл.....	8
3. Менежментийн захидал	9
4. Аудит хийсэн санхүүгийн тайлан.....	11
4.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан.....	11
4.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан.....	12
4.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан	14
4.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан	16
4.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан.....	17
5. Аудитын явцад илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт	19

Товчилсон үгийн жагсаалт

ҮАГ	Үндэсний аудитын газар
САГ	Санхүүгийн аудитын газар
СТА	Санхүүгийн тайлангийн аудит
ТШЗ	Төсвийн шууд захирагч
ГЕГ	Гаалийн ерөнхий газар
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газар
СААА	Санхүү, аж ахуйн алба
УСНББОУС	Улсын Секторын Нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт
АДБОУС	Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт
АОУС	Аудитын олон улсын стандарт



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг
Бага тойруу-3, Засгийн газрын IV байр
Утас:26-04-37, Факс:51-26-42-30
E-mail: info@audit.gov.mn

УЛААНБААТАР ХОТ ДАХЬ ГААЛИЙН
ГАЗРЫН ДАРГА Д.СОЛОНГО ТАНАА

2020.02.27 № 06/640
танай _____-ны № _____-т

Аудитын гэрчилгээ

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Улаанбаатар хот дахь Гаалийн газрын 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд санхүүгийн тайлангийн аудит хийв.

Зөрчилгүй санал дүгнэлт

Улаанбаатар хот дахь Гаалийн газрын 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээ болон төсвийн гүйцэтгэлийн тайланг материаллаг зүйлсийн хувьд Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, УСНББОУС-д нийцүүлж, Сангийн сайдын баталсан бодлого, журам, зааврын дагуу үнэн, бодитой, шударга илэрхийлсэн тул зөрчилгүй санал дүгнэлт гаргаж байна.

Санал дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартад нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторовын баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журам, зааврын дагуу гүйцэтгэсэн. Эдгээр нь санхүүгийн тайлан материаллаг буруу илэрхийллээс ангид эсэх талаар үндэслэлтэй баталгаа олж авах зорилгоор аудитыг төлөвлөж, гүйцэтгэхийг шаарддаг.

Аудитаар Улаанбаатар хот дахь Гаалийн газрын 2019 оны жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайлан дах үлдэгдэл, ажил гүйлгээний дүн хэмжээ болон илчлэл тодруулга, тус байгууллагад мөрдөж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, бүртгэл хөтлөлт, программ хангамж, дотоод хяналтын систем болон удирдлагын хийсэн томоохон тооцооллыг шалгаж, аудитын санал дүгнэлтийг дэмжих нотлох зүйлсийг хангалттай цуглуулсан.


Бидний хийсэн аудит тус санхүүгийн тайлан, тодруулгад санал дүгнэлт өгөх хангалттай, зохистой үндэслэлийг бүрдүүлсэн бөгөөд аудитын дүнд үндэслэсэн санал, зөвлөмжийг аудитын тайланд тусгасан болно.

Үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч нь Төсвийн тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.1–д заасны дагуу тайлант хугацааны санхүүгийн тайлан, тодруулгыг Нягтлан бодох бүртгэлийн болон Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, түүнтэй нийцүүлэн Сангийн сайдын баталсан журам, зааврын дагуу бэлтгэж, тайлагнах үүрэгтэй.

Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартын дагуу аудит хийж, жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайланд санал дүгнэлт өгөх нь төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

САНХҮҮГИЙН АУДИТЫН
ГАЗРЫН ЗАХИРАЛ БӨГӨӨД
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ц.НАРАНЧИМЭГ

2. Аудитын тайлан

2.1. Оршил

Улаанбаатар хот дахь Гаалийн газрын 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын дүн, дүгнэлтийг Улаанбаатар хот дахь Гаалийн газрын дарга Д.Солонго Танд танилцуулж байна.

Энэхүү тайланд үйлчлүүлэгчийн санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтын системд хийсэн үнэлгээний тойм, аудитын явцад илрүүлсэн гол зүйлс, гаргасан шийдлүүд, анхаарал хандуулахуйц асуудал, залруулаагүй материаллаг болон материаллаг бус алдаа зөрчил, тодруулга зэрэг аудитын үр дүн, аудитын дүгнэлтийн хэлбэр, түүний үндэслэлийн талаар тус тус хураангуйлан тэмдэглэв.

Аудитын дүнд үндэслэсэн үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэл, тайлагнал, дотоод хяналтын системийг боловсронгуй болгох зөвлөмжүүдийг Менежментийн захидалд тусгасан болно.

Дараагийн заалтад аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг батлагдсан ангилал, үзүүлэлтээр бэлтгэж оруулав.

2.2. Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага

Бид Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 15.2, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Улаанбаатар хот дахь Гаалийн газрын 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болгосон санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Улаанбаатар хот дахь Гаалийн газрын 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн гаргасан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, заавар, журмын дагуу үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь энэхүү аудитын зорилт байв.

Төсвийн шууд захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлангаа Төсвийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын дагуу үнэн зөв, бодитой бэлтгэх үүрэгтэй.

Харин тухайн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг дээрх хууль болон бодлого, журмын дагуу материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн эсэхэд дүгнэлт өгөх нь Төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

Аудитыг 2019 оны 11 дүгээр сарын 11-нээс 2020 оны 02 дугаар сарын 10-ны хооронд гүйцэтгэж, аудитын тайланг 2020 оны 02 дугаар сарын 21-ний өдөр эцэслэн баталгаажуулж, төсвийн шууд захирагчид хүргүүлэхээр төлөвлөн, Үндэсний аудитын газрын захиалгаар “Нийслэл-Аудит” ХХК хариуцаж хэрэгжүүлэв.

Улаанбаатар хот дахь Гаалийн газар 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг “Нийслэл-Аудит” ХХК-д 2020 оны 01 дүгээр сарын 21-ний өдрийн 01/38 дугаар бүхий албан бичгээр ирүүлсэн байна.

2.3. Аудитад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт

Аудитын явцад АДБОУС, АОУС, нийтээр хүлээн зөвшөөрсөн бусад зарчимд тулгуурласан төрийн аудитын байгууллагын санхүүгийн тайлангийн аудитын талаарх бодлого, арга зүйг мөрдөж ажиллав.

Дээрх стандарт, зарчим, журамд нийцүүлж Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Төрийн аудитын байгууллагаас аудитын үе шатны ажлыг гүйцэтгэж, холбогдох ажлын баримт материалаар баталгаажуулсан болно.

2.4. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин

Улаанбаатар хот дахь Гаалийн газрын үйл ажиллагааны эрхэм зорилго нь үндэсний аюулгүй байдлыг хамгаалах, олон улсын хууль ёсны худалдааг хөнгөвчлөх, улсын төсвийн орлогыг бүрдүүлэх, байгууллагын чадавхийг бэхжүүлэхэд оршино.

Улаанбаатар хот дахь Гаалийн газрын үйл ажиллагааны чиглэлийг дараах байдлаар тодорхойлжээ. Үүнд:

- Гадаад худалдааг хөнгөвчлөх;
- Улсын хилээр хууль бусаар бараа, тээврийн хэрэгслийг нэвтрүүлэхтэй тэмцэх;
- Олон улсын хууль ёсны худалдааг хөнгөвчлөх, түүний аюулгүй байдлыг хамгаалах;
- Улсын төсвийн орлогыг шударга үр ашигтай, үр дүнтэй бүрдүүлэх;
- Гаалийн байгууллагын дэд бүтэц, чадавхийг бэхжүүлэх.

2.5. Нягтлан бодох бүртгэлийн бодлого, санхүүгийн үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ

Бид санхүүгийн тайланд материаллаг алдаа байхгүй гэдгийг нягтлах үүднээс үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэлийн бодлого, санхүүгийн үйл ажиллагаа, дотоод хяналтыг шаардлагатай гэж үзсэн хэмжээгээр дахин хянасан болно.

Тус газрын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь Сангийн яамнаас хэрэгжүүлж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, холбогдох стандарт, хууль тогтоомжтой нийцсэн байна.

Улаанбаатар хот дахь Гаалийн газар нь санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаанд “Unicus” программ хангамж ашигладаг байна.

Улаанбаатар хот дахь Гаалийн газрын дотоод хяналтын эрсдэлийг төлөвлөлтийн үе шатанд “дунд” гэж үнэлсэн бөгөөд гүйцэтгэлийн шатанд дахин хянахад дотоод хяналт үр нөлөөтэй байна.

2.6. Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал

Аудитаар Улаанбаатар хот дахь Гаалийн газрын бэлтгэсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл нь материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэсэн үндэслэлтэй нотолгоо олж авахын тулд байгууллагын гадаад дотоод орчин, дотоод хяналтыг судлан, эрсдэлтэй асуудлыг илрүүлж, үнэллээ.

Аудитын төлөвлөлтийн үе шатанд 11 эрсдэлтэй асуудалд горим сорил хэрэгжүүлэхээр төлөвлөж баталгаажуулсан болно.

2.7. Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар

Аудитыг төлөвлөх үе шатны материаллаг байдлыг АДБОУС 1320, АОУС 320-ын дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2019 оны эхний хагас жилийн тайлангийн нийт зардлыг сонгож, эрсдэлийн түвшинг “дунд” гэж үнэлэн материаллаг байдлын хувь хэмжээг 2.0 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн үе шатанд сонгосон суурь үзүүлэлтийн дүн 2,873,838.2 мянган төгрөгөөс тооцон 57,476.8 мянган төгрөгөөр материаллаг байдлыг тодорхойлж, баталгаажууллаа.

Гүйцэтгэлийн үе шатанд материаллаг байдлын түвшинг нийт зардлын 2.0 хувиар буюу 120,126.1 мянган төгрөгөөр тооцсон болно.

2.8. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ҮЗҮҮЛЭЛТҮҮД

Улаанбаатар хот дахь Гаалийн газрын 2019 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 892,316.9 мянган төгрөгөөр буюу 9.1 хувиар буурсан байна. Өмнөх оны үзүүлэлтээс бараа материал 82,401.4 мянган төгрөгөөр өсч, харин үндсэн хөрөнгө 972,152.9 мянган төгрөгөөр буурсан байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	0	0	0
Авлага	2,565.4	0.0	-2,565.4
Урьдчилгаа	0	0	0
Бараа материал	67,212.3	149,613.7	82,401.4
Үндсэн хөрөнгө	9,732,203.9	8,760,051.0	-972,152.9
Нийт хөрөнгө	9,801,981.6	8,909,664.7	-892,316.9
Өр төлбөр	172.4	0	-172.4
Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/	6,849,976.5	6,849,976.5	0.0
Хуримтлагдсан үр дүн	2,950,382.7	2,058,238.2	-892,144.5
Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	1,450.0	1,450.0	0.0
Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн	9,801,981.6	8,909,664.7	(892,316.9)

Тус газар нь 2019 оны санхүүгийн тайлангаар авлага, өр төлбөргүй тайлагнагдсан байна. Оны эхэнд байгууллагад 2,565.4 мянган төгрөгийн авлага, хувь хүнд 172.4 мянган төгрөгийн өртэй байсныг тайлант хугацаанд барагдуулсан байна.

Бараа материалын дансны үлдэгдэл 82,401.4 мянган төгрөгөөр өссөн нь бэлэн бүтээгдэхүүн 35,355.2 мянган, бичиг хэргийн материал 29,962.3 мянган, аж ахуйн материал 12,992.9 мянган төгрөгөөр өссөнөөс шалтгаалжээ.

Гаалийн ерөнхий газрын 2019 оны 06 дугаар сарын 25-ны өдрийн А/137 тоот тушаалын дагуу машин, тоног төхөөрөмж дансанд 392,703.3 мянган төгрөгийн хөрөнгө, мөн өдрийн А/138 тоот тушаалын дагуу машин тоног төхөөрөмжийн дансанд 3,091.2 мянган төгрөгийн хөрөнгө (386,4 мянган төгрөгийн хуримтлагдсан элэгдэл), мөн тушаалын дагуу тавилга эд хогшлын дансанд 4,105.1 мянган төгрөгийн хөрөнгө (1,077,7 мянган төгрөгийн хуримтлагдсан элэгдэл)-ийг тус тус орлого болгожээ.

Мөн Гаалийн ерөнхий газрын даргын 2019 оны 11 дүгээр сарын 15-ны өдрийн А/252 тоот тушаалын дагуу тавилга эд хогшлын дансанд 14,302.0 мянган төгрөгийн балансын үнэтэй (3,301.9 мянган төгрөгийн хуримтлагдсан элэгдэл) хөрөнгийг балансаас балансад шилжүүлж, мөн өдрийн А/254 тоот тушаалын дагуу машин тоног төхөөрөмжийн дансанд 2,118.3 мянган төгрөгийн хөрөнгө, биет бус хөрөнгийн дансанд 330.0 мянган төгрөгийн хөрөнгийг тус тус шинээр орлого болгон авсан байна.

Гаалийн ерөнхий газрын 2019 оны 12 дугаар сарын 30-ны өдрийн А/312 тоот тушаалын дагуу барилга байгууламжийн дансанд 510,529.4 мянган төгрөгийн капитал засвар (дотоод засвар) хийж, тухайн дансанд капиталжуулсан хөрөнгөөр дансанд бүртгэж, мөн өдрийн А/314 тоот тушаалын дагуу машин тоног төхөөрөмжийн дансанд 1,600.0 мянган төгрөгийн хөрөнгө, А/321 тоот тушаалын дагуу тавилга эд хогшлын дансанд 9,267.9 мянган төгрөгийн балансын

үнэтэй (7,077.9 мянган төгрөгийн хуримтлагдсан элэгдэл) хөрөнгийг балансаас балансад шилжүүлэн бүртгэлд тусгасан байна.

2019 оны жилийн эцсийн байдлаар үндсэн хөрөнгийн данснаас 2019 оны 12 дугаар сарын 30-ны өдрийн А/315 тоот тушаалын дагуу 4,105.1 мянган төгрөгийн хөрөнгө (1,230.7 мянган төгрөгийн хуримтлагдсан элэгдэл)-ийг тавилга эд хогшлын данснаас Гаалийн ерөнхий газрын Санхүү, аж ахуйн албанд балансаас балансад шилжүүлжээ.

Гаалийн ерөнхий газрын даргын А/304 тоот тушаалын дагуу 15,912.3 мянган төгрөгийн хөрөнгийг дахин ашиглагдах боломжгүй, ашиглалтын хугацаа дууссан тул акталжээ.

2.9. Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн шууд захирагч нь энэ хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

Улаанбаатар хот дахь Гаалийн газарт 2019 онд улсын төсвөөс 4,130,552.8 мянган, орон нутгийн төсвөөс 10,000.0 мянган, нийт 4,140,552.8 мянган төгрөгийн төсөв батлагдсанаас гүйцэтгэлээр 4,079,252.2 мянган төгрөгийг зарцуулж, батлагдсан төсвийг 61,300.6 мянган төгрөг буюу 1.48 хувиар хэмнэжээ.

Урсгал зардлын гүйцэтгэлээс үзэхэд тус газрын хувьд нийт зардлын 82.9 хувь буюу 3,363,961.4 мянган төгрөг нь үндсэн цалин, нэмэгдэл цалин, унаа, хоолны хөнгөлөлт, урамшуулалтай холбогдон гарсан байна. Харин нийгмийн даатгалд төлөх шимтгэлд 10.2 хувь буюу 412,866.3 мянган төгрөг зарцуулжээ. Үлдсэн 6.9 хувь буюу 279,037.6 мянган төгрөг нь байр ашиглалт, хангамж, материал худалдан авах, урсгал засвар, бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээ, бусад зардалд зарцуулагджээ.

Тус газар нь тайлант онд өөрийн байрыг бусдад түрээслүүлснээс 77,956.1 мянган төгрөгийн орлого төвлөрүүлж, 70 хувь буюу 54,569.3 мянган төгрөгийг улсын төсөвт, үлдсэн 30 хувь буюу 23,386.8 мянган төгрөгийг ТӨБЗГ (Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар)-т шилжүүлсэн байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр харуулсан мэдээллийг энэ тайлангийн 4.5-д харуулав.

2.10. Аудитаар хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн

Аудитыг төлөвлөх үе шатанд тогтоосон 11 эрсдэл тогтоосон бөгөөд гүйцэтгэх үе шатанд 8 эрсдэл тодорхойлж, нийт 12 горим сорил хэрэгжүүллээ.

Аудитаар Гаалийн ерөнхий газраас Улаанбаатар хот дахь Гаалийн газарт гадаад худалдааны бараа эргэлт нэмэгдсэнтэй холбогдуулан гаалийн улсын байцаагчийг нэмж ажиллуулан батлагдсан төсөвт орон тоог 15-аар хэтрүүлсэн алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх талаар нэг зөвлөмж өгч менежментийн захидалд тусгалаа.

2.11. ДАРААГИЙН АУДИТААР АВЧ ҮЗЭХ БУЮУ АНХААРАЛ ТАТАХУЙЦ БУСАД ЧУХАЛ АСУУДАЛ

Улаанбаатар хот дахь Гаалийн газрын орон тоо, бүтэц, зохион байгуулалтын асуудлыг анхаарч үзэхийг Гаалийн ерөнхий газрын удирдлагад тавих нь зүйтэй гэж үзлээ.

2.12. Шилэн дансны мэдээлэл

Тус газар нь Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан 46 мэдээллийг тогтоосон хугацаанд нь бүрэн байршуулсан байна.

2.13. ӨМНӨХ АУДИТААР ӨГСӨН АКТ, АЛБАН ШААРДЛАГА, ЗӨВЛӨМЖИЙН ХЭРЭГЖИЛТ

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн 2,565.4 мянган төгрөгийн зөрчилд зөвлөмж өгснийг бүрэн хэрэгжүүлсэн байна.

2.14. Дүгнэлтийн хэлбэр, үндэслэл

Бид Улаанбаатар хот дахь Гаалийн газрын 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланд аудит хийж, баталгаажуулах ажлыг АДБОУС-ын дагуу, Монгол Улсын холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн гүйцэтгэсэн.

“Зөрчилгүй” дүгнэлт

Улаанбаатар хот дахь Гаалийн газрын 2019 оны жилийн эцсийн санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, өмчийн өөрчлөлт болон бусад илчлэл тодруулгыг холбогдох хууль, УСНББОУС-ын дагуу материаллаг байдлын хувьд үнэн зөв, бодитой илэрхийлсэн эсэхийг Аудитын гэрчилгээнд тодорхой дурдав.

3. Менежментийн захидал

Төрийн аудитын байгууллага санхүүгийн тайлангийн аудит бүрийн төгсгөлд аудитаар илрүүлсэн зүйлсийг нэгтгэсэн менежментийн захидлыг үйлчлүүлэгч, түүний удирдлагад зориулж бэлтгэдэг бөгөөд түүнд санхүү, нягтлан бодох бүртгэл, тайлагналын бодлого, үйл ажиллагаа, дотоод хяналтыг сайжруулах зөвлөмжийг тусгадаг.

Энэхүү менежментийн захидлын агуулга аудитын үр дүн, дүгнэлтээс урган гарсан болно. Санхүүгийн тайлан, бусад илчлэл тодруулгын талаар санал дүгнэлт гаргахад бидний бодлого, горим зориулагдсан.

Энэ нь нягтлан бодох бүртгэлийн бодлого, горимыг зөвхөн аудитыг үр нөлөөтэй гүйцэтгэхэд шаардагдах цар хүрээнд дахин хянасан бөгөөд оршиж буй бүх сул талыг гаргаж ирэх боломжгүй юм.

Тиймээс аудитын тайланд тусгасан зөвлөмж нь аудит хийх үеийн нөхцөл байдлын талаарх бидний үнэлэлт, дүгнэлтийг илэрхийлж байгаа болно.

Харин эдгээр зөвлөмжийг та бидний хамтын ажиллагааны байр сууринаас гаргасан бөгөөд аудитаар өгсөн зөвлөмжийг хүлээн авч, хэрэгжүүлэх нь танай үүрэг хариуцлага юм.

Менежментийн захидалд дурдсан цаашид санхүүгийн тайланд шууд бөгөөд материаллаг хэмжээгээр нөлөөлж болзошгүй тул анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлоор нь эрэмбэлэн үзүүлэв. Үүнд:

Асуудал 1: Батлагдсан орон тоо хэтрүүлсэн талаар:

3.1 Зардлын данстай холбоотой асуудал

3.1.1 Илрүүлэлт: Гаалийн ерөнхий газрын даргын 2017 оны 11 дүгээр сарын 02-ны өдрийн А/249 тоот тушаалаар “Зохион байгуулалтын бүтэц, орон тоог шинэчлэн батлах тухай” тушаалын 2 дугаар хавсралтаар Улаанбаатар хот дахь Гаалийн газрыг 189 орон тоотой байхаар баталжээ.

Тайлант онд Гаалийн ерөнхий газраас Улаанбаатар хот дахь Гаалийн газарт гадаад худалдааны бараа эргэлт нэмэгдсэнтэй холбогдуулан гаалийн улсын байцаагчийг нэмж ажиллуулан батлагдсан төсөвт орон тоог 15-аар хэтрүүлсэн байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6.6.4 “*төсвийн захирагч нь төсвийн жилийн дундуур энэ хуулиар олгогдсон бүрэн эрхийнхээ хүрээнд тухайн жилийн төсөвтөө өөрчлөлт оруулж, зохицуулалт хийсэн бол гүйцэтгэлийг нь анхны батлагдсан зорилт, хүрэх үр дүнтэй харьцуулж тайлагнадаг байх*” гэсэн заалтыг зөрчсөн байна.

3.2.2 Эрсдэл: Батлагдсан төсөвт зардал хэтрэх, ялангуяа цалин, нийгмийн даатгалын шимтгэл хэтэрч зарцуулагдах;

3.2.3 Өгсөн зөвлөмж: Гаалийн ерөнхий газрын даргын 2017 оны 11 дүгээр сарын 02-ны өдрийн “Зохион байгуулалтын бүтэц, орон тоог шинэчлэн батлах тухай” тушаалыг мөрдөж, батлагдсан орон тоог хэтрүүлэхгүй ажиллах;

3.2.4 Байгууллагаас өгсөн хариу тайлбар: Тус газарт гадаад худалдааны бараа эргэлт нэмэгдсэнтэй холбоотойгоор “Амгалан өртөө”-ний урд байрлах “Амгалан Ложистик” ХХК-тай гэрээ байгуулж, Гаалийн тухай хууль, холбогдох журмыг хэрэгжүүлж ажиллаж байгаатай холбогдуулан улсын байцаагчийн орон тоог нэмж ажиллуулсан болно. Өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлж ажиллах болно.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2020 оны 07 дугаар сарын 25-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

4. Аудит хийсэн санхүүгийн тайлан

4.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөг/

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	69,777,759.61	149,613,723.65
33	АВЛАГА	2,565,446.86	-
3305	Бусад авлага	2,565,446.86	
330501	Байгууллагаас авах авлага	2,565,446.86	
35	БАРАА МАТЕРИАЛ	67,212,309.75	149,613,723.65
3501	Түүхий эд материал	-	-
3503	Бэлэн бүтээгдэхүүн	29,083,165.35	64,438,409.35
3504	Хангамжийн материал	38,129,144.40	85,175,314.30
35401	Бичиг хэргийн материал	4,641,940.00	34,604,187.00
35402	Аж ахуйн материал	26,783,456.60	42,776,379.50
35404	Түлш, тослох материал	1,305,000.00	2,396,000.00
35470	Бусад хангамжийн материал	5,398,747.80	5,398,747.80
36	НӨӨЦИЙН БАРАА	-	-
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН БАРАА	9,732,203,892.48	8,760,051,006.96
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	9,732,203,892.48	8,760,051,006.96
392	БИЕТ ХӨРӨНГӨ	9,635,905,772.48	8,663,436,636.96
39201	Барилга байгууламж орон сууц	4,930,334,929.00	5,440,864,311.00
3920101	Хуримтлагдсан элэгдэл	519,878,292.72	620,448,914.88
39202	Авто-тээврийн хэрэгсэл	158,112,170.00	158,112,170.00
3920201	Хуримтлагдсан элэгдэл	80,513,558.95	102,730,225.63
39205	Машин тоног төхөөрөмж	7,058,460,138.96	7,442,894,908.96
3920301	Хуримтлагдсан элэгдэл	2,018,715,699.67	3,737,589,641.20
39204	Тавилга, аж ахуйн эд хогшил	345,514,332.06	368,205,271.06
3920401	Хуримтлагдсан элэгдэл	250,074,912.72	296,537,908.83
39208	Бусад үндсэн хөрөнгө	20,000,000	20,000,000
39208	Хуримтлагдсан элэгдэл	7,333,333.48	9,333,333.52
3903	Биет бус хөрөнгө	96,298,120.00	96,614,370
39301	Програм хангамж	3,200,000	3,530,000
3930101	Хуримтлагдсан элэгдэл	3,200,000	3,213,750
39302	Бусад биет бус хөрөнгө	96,298,120	96,298,120
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН	9,801,981,649.09	8,909,664,730.61
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	173,377.43	-
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	172,377.43	
413	Өглөг	172,377.43	
4136	Бусад өглөг	172,377.43	
413602	Хувь хүмүүст өгөх өглөг	172,377.43	
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ, ӨМЧИЙН ДҮН	9,801,809,271.66	8,909,664,730.61
51	Засгийн газрын хувь оролцоо	6,849,976,358.38	6,849,976,358.38
5101	Засгийн газрын оруулсан капитал	6,849,976,358.38	6,849,976,358.38
5102	Хуримтлагдсан үр дүн	2,950,382,690.43	2,058,238,149.38
510201	Өмнөх үеийн үр дүн	2,950,382,690.43	2,950,382,690.43
510202	Тайлант үеийн үр дүн	-	-892,144,541.05
5103	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	1,450,222.85	1,450,222.85
6	НИЙТ ӨР ТӨЛБӨРЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	9,801,981,649.09	8,909,664,730.61

4.2 Аудит хийсэн САНХҮҮГИЙН ҮР ДҮНГИЙН ТАЙЛАН

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөг/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН	4,004,999,721.43	5,114,161,818.34
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	311,384,721.43	1,035,609,018.34
120	Нийтлэг татварын бус орлого	311,384,721.43	1,035,609,018.34
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	264,035,627.43	957,652,890.34
200044	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	264,035,627.43	957,652,890.34
120005	Түрээсийн орлого	47,349,094.00	77,956,128.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	3,693,615,000.00	4,078,552,800.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	3,693,615,000.00	4,068,552,800.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	3,693,615,000.00	4,068,552,800.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	-	10,000,000.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт/орон нутгийн төсөвт байгууллага/	-	10,000,000.00
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	5,606,331,313.66	6,002,207,044.63
21	УРСГАЛ ЗАСВАР	3,458,041,099.83	3,779,220,764.59
210	БАРАА АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	5,515,665,065.12	5,913,187,128.67
21	ЦАЛИН ХӨЛС, НДШ	3,458,041,099.83	3,779,220,764.59
2101	Цалин хөлс болон нэмэгдэл, урамшуулал	3,088,789,738.94	3,357,774,142.45
210101	Үндсэн цалин	2,967,913,738.94	3,207,278,542.45
210103	Унаа хоолны хөнгөлөлт	120,876,000.00	150,495,600.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	369,251,360.89	421,446,622.14
210201	Тэтгэврийн даатгал	246,438,338.94	288,131,272.89
210202	Тэтгэмжийн даатгал	24,562,604.50	26,663,070.33
210203	ҮОМШӨ-ний даатгал	30,703,255.37	33,328,836.40
210204	Ажилгүйдлийн даатгал	6,140,650.64	6,665,766.33
210205	Эрүүл мэндийн даатгал	61,406,511.44	66,657,676.19
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	51,690,339.26	82,204,809.27
210301	Гэрэл, цахилгаан	33,420,826.00	65,526,948.00
210302	Түлш халаалт	14,564,283.00	12,714,714.86
210303	Цэвэр, бохир ус	3,705,230.26	3,963,146.41
2104	Хангамж, бараа материалын зардал	30,220,638.94	41,439,724.26
210401	Бичиг хэрэг	10,080,150.00	26,634,768.00

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
210402	Тээвэр, шатахуун	6,049,000.00	9,628,600.00
210403	Шуудан, холбоо, интертетиин төлбөр	3,192,337.94	2,793,563.26
210404	Ном, хэвлэл	4,668,600	-
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	710,000.00	780,000.0
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх ахуйн эд зүйлс	5,520,551.00	1,602,793.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	21,797,108.00	16,252,747.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	139,600	
210604	Урсгал засвар	21,657,508.00	16,252,747.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний төлбөр, хураамж	105,770,317.40	86,979,431.33
210801	Бусдаас гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	31,571,691.00	30,456,184.35
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	3,900,000.00	3,000,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	2,652,290.00	2,287,743.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	97,000.00	88,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	661,426.00	429,000.00
210807	Газрын төлбөр	261,700.00	591,800.00
210809	Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх	66,626,210.40	50,126,703.98
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	1,848,145,561.69	1,907,089,652.22
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	5,580,000.00	13,088,598.00
210902	Хичээл үйлвэрлэлийн дадлага хийх	125,000.00	6,217,400.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	1,842,440,561.69	1,887,783,654.22
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	90,666,248.54	89,019,915.96
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	90,666,248.54	89,019,915.96
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	90,666,248.54	89,019,915.96
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН	-1,601,331,592.23	-888,045,226.29
4	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ОРЛОГЫН ДҮН	-	-
5	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	20,222,222.12	4,099,314.76
225005	Үнэ төлбөргүй гарсан зардал	20,222,222.12	4,099,314.76
6	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН	-1,621,553,814.35	-892,144,541.05

4.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөг/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН	3,761,663,112.00	4,156,508,928.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	68,048,112.00	77,956,128.00
120	Нийтлэг татварын бус орлого	68,048,112.00	77,956,128.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	406,550.00	
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	406,550.00	
120005	Түрээсийн орлого	67,641,562.00	77,956,128.00
13	ТУСЛАМЖ САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	3,693,615,000.00	4,078,552,800.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	3,693,615,000.00	4,068,552,800.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	3,693,615,000.00	4,068,552,800.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	-	10,000,000
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт/орон нутгийн төсөвт байгууллага/	-	10,000,000
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	3,761,663,112.00	4,156,508,928.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	3,460,655,659.26	3,776,827,695.16
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	3,650,704,395.46	4,055,865,344.04
21	ЦАЛИН ХӨЛ, НЭМЭГДЭЛ НДШ	3,460,655,659.26	3,776,827,695.16
2101	Цалин хөлс, нэмэгдэл урамшуулал	3,095,495,899.54	3,363,961,395.16
210101	Үндсэн цалин	1,535,893,544.91	1,635,629,095.16
210102	Нэмэгдэл	1,042,861,954.63	1,144,502,900.00
210103	Унаа хоолны хөнгөлөлт	156,740,400.00	209,229,400.00
210104	Урамшуулал	360,000,000.00	374,600,000.00
2102	Ажил олгогчоос НД-д төлөх шимтгэл	365,159,759.72	412,866,300.00
210201	Тэтгэврийн даатгал	365,159,759.72	412,866,300.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	52,156,423.26	82,165,709.27
210301	Гэрэл, цахилгаан	33,313,400.00	63,669,281.00
210302	Түлш, халаалт	15,359,283.00	14,572,381.86
210303	Цэвэр, бохир ус	3,483,740.26	3,924,046.41
2104	Хангамж, бараа материалын зардал	24,846,663.94	40,175,853.26
210401	Бичиг хэрэг	12,001,500.00	25,191,320.00
210402	Тээвэр, шатахуун	6,557,000	9,208,000.00
210403	Шуудан холбоо, интернетийн төлбөр	3,299,763.94	2,793,563.26
210405	Хог хаягдал зайлуулах хортон мэрэгчийн устгал, ариутгал	816,800.00	811,370.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	2,171,600.00	2,171,600.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	51,980,000.00	34,408,973.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	1,175,000	4,865,500
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэгсэл	990,000	807,821
210604	Урсгал засвар	49,815,000.00	28,735,652.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр хураамж	60,765,649.00	105,682,613.35
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр хураамж	42,325,960.00	41,823,670.35
210802	Аудит баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	3,900,000.00	3,000,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	2,377,915.00	2,014,168.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	274,375.00	273,575.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	97,000.00	88,000.00
210806	Мэдээлэл технологийн үйлчилгээ	1,228,699.00	16,698,700.00
210807	Газрын төлбөр	261,700.00	591,800.00
210809	Улсын мэдээллийн маягт хэвлэх бэлтгэх	10,300,000.00	41,192,700.00
2109	БАРАА ҮЙЛЧИЛГЭЭНИЙ БУСАД ЗАРДАЛ	300,000.00	16,604,500.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	300,000.00	16,604,500.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	110,958,716.54	100,643,583.96

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
2133	Улсын төсвөөс орсон санхүүжилт шилжүүлэг	-	11,763,168.60
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг		77,256,747.36
2134	ОРОН НУТГИЙН ЕРӨНХИЙЛӨН ЗАХИРАГЧИДАД ОЛГОХ ТАТААС, САНХҮҮЖИЛТ	20,292,468.00	11,623,668.00
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	20,292,468.00	11,623,668.00
2135	Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг	90,666,248.54.00	-
213503	Төвлөрүүлэх шилжүүлэг	90,666,248.54	
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	-	-
9	МӨНГӨ ТҮҮНТЭЙ АДИЛТГАХ ХӨРӨНГИЙН ЭХНИЙ ҮЛДЭГДЭЛ	-	-
10	МӨНГӨ ТҮҮНТЭЙ АДИЛТГАХ ОРЛОГЫН ЭЦСИЙН ҮЛДЭГДЭЛ	-	-

4.4 Аудит хийсэн ЦЭВЭР ХӨРӨНГӨ/ӨМЧИЙН ӨӨРЧЛӨЛТИЙН ТАЙЛАН

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөг/

Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан үр дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
2017 оны 12 дугаар сарын 31-ээр үлдэгдэл	-	-	-	-
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	96,298,100.00	-	-	96,298,100.00
Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт	-	-	-	-
Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний бууралт	-	-	-	-
Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	-	-	-	-
Тайлант үеийн үр дүн			- 1,621,553,814.35	-1,621,553,814.35
2018 оны 12 дугаар сарын 31-ний үлдэгдэл	6,849,976,358.38	1,450,222.85	2,950,382.690.43	9,801,809,271.66
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	-	-
Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт	-	-	-	-
Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний бууралт	-	-	-	-
Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	-	-	-	-
Тайлан үеийн үр дүн	-	-	-892,144,541.05	-892,144,541.05
2019 оны 12 дугаар сарын 31-ний үлдэгдэл	6,849,976,358.38	1,450,222.85	2,058,238,149.38	8,909,664,730.61

4.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөг/

Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	4,140,552,800.00	4,079,252,180.64	61,300,619.36	98.52
НИЙТ ЗАРЛАГЫН ДҮН	4,140,552,800.00	4,079,252,180.64	61,300,619.36	98.52
УРСГАЛ ЗАРДЛЫН ДҮН	4,140,552,800.00	4,055,865,344.04	84,687,455.96	97.95
БАРАА ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	292,316,100.00	279,037,648.88	13,278,451.12	95.46
Цалин хөлс болон нэмэгдэл суутгал	3,435,370,400.00	3,363,961,395.16	71,409,004.84	97.92
Үндсэн цалин	1,707,038,100.00	1,635,629,095.16	71,409,004.84	95.82
Нэмэгдэл цалин	1,144,502,900.00	1,144,502,900.00	0	100
Унаа хоолны нэмэгдэл	209,229,400.00	209,229,400.00	0	100
Урамшуулал	374,600,000	374,600,000	0	100
АЖИЛ ОЛГОГЧООС НИЙГМИЙН ДААТГАЛД ТӨЛӨХ ШИМТГЭЛ	412,866,300.00	412,866,300.00	0	100
Тэтгэврийн даатгал	412,866,300	412,866,300	0	100
Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	94,750,900.00	82,165,709.27	12,585,190.73	86.72
Гэрэл цахилгаан	71,158,300.00	63,669,281.00	7,489,019	89.48
Түлш халаалт	19,603,600.00	14,572,381.86	5,031,218.14	74.34
Цэвэр бохир ус	3,989,000.00	3,924,046.41	64,953.59	98.37
Хангамж бараа, материалын зардал	40,498,300.00	40,175,853.26	322,446.74	99.20
Бичиг хэрэг	25,201,500.00	25,191,320.00	10,180.00	99.96
Тээвэр шатахуун	9,208,600.00	9,208,000.00	600.00	99.99
Шуудан холбоо, интернетийн төлбөр	3,099,800.00	2,793,563.26	306,236.74	90.12
Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал ариутгал	816,800.00	811,370.00	5,430.00	99.34
БҮТЭЗүйлс	2,171,600.00	2,171,600.00	0	100
Эд хогшил урсгал засварын зардал	34,410,000.00	34,408,973.00	1,027.00	100
Багаж техник хэрэгсэл	4,865,500.00	4,865,500.00	0	100
Хөдөлмөр хамгааллын хэрэгсэл	808,200.00	807,821.00	379.00	99.95
Урсгал засвар	28,736,300.00	28,735,652.00	648.00	100
Бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний төлбөр хураамж	106,052,400.00	105,682,613.35	369,786.65	99.65
Бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	41,854,400.00	41,823,670.35	30,729.65	99.93
Аудит баталгаажуулалт зэрэглэл тогтоох	3,000,000.00	3,000,000.00	0	100
Даатгалын үйлчилгээ	2,258,000.00	2,014,168.00	243,832.00	89.20
Тээврийн хэрэгслийн татвар	309,500.00	273,575.00	35,925.00	88.39
Тээврийн хэрэгслийн оношлогоо	140,000.00	88,000.00	52,000.00	62.86
Мэдээлэл технологийн үйлчилгээ	16,698,700.00	16,698,700.00	0	100
Газрын төлбөр	591,800.00	591,800.00	0	100
Улсын мэдээллийн маягт хэвлэх бэлтгэх	41,200,000.00	41,192,700.00	7,300.00	99.98
Бараа үйлчилгээний бусад зардал	16,604,500.00	16,604,500.00	0	100

Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	16,604,500.00	16,604,500.00	0	100
УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ		23,386,836.60	-23,386,836.60	
Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчид олгох татаас санхүүжилт		23,386,836.60	-23,386,836.60	
Төвлөрүүлэх шилжүүлэг		23,386,836.60	-23,386,836.60	
ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	4,140,552,800.00	4,079,252,180.64	61,300,619.36	98.5
ТАТВАРЫН БУС ОРЛОГО	77,956,128.00	77,956,128.00		100
Төрийн өмчийг түрээслүүлсний орлого	77,956,128.00	77,956,128.00		100
ҮНДСЭН БУС ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГО				
ТУСЛАМЖ САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	10,000,000.00	10,000,000.00		100
Улсын төсвөөс санхүүжих	4,052,596,672.00	3,991,296,052.64	61,300,619.36	98.5
Орон нутгийн төсвөөс санхүүжих				
МӨНГӨН ХӨРӨНГИЙН ЭЦСИЙН ҮЛДЭГДЭЛ				
Удирдах ажилтан	3	3		
Гүйцэтгэх ажилтан	163	178	15	109.2
Үйлчлэх ажилтан	20	20		
Гэрээт ажилтан	3	3		

5. Аудитын явцад илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт

Огноо:	2020.02.20	Аудитын нэр:	2019 оны санхүүгийн аудитын тайлан	Аудитын код:
				САГ-2020/106/СТА-ТШЗ
Шалгагдсан байгууллагын нэр:	Улаанбаатар хот дахь Гаалийн газрын 2019 оны санхүүгийн тайлангийн аудит			Мянган төгрөгөөр

№	Алдаа, зөрчлийн товч утга	Мөнгөн дүн	Аудитын байгууллагаас гаргасан шийдэл	Алдаа, зөрчилтэй асуудал гаргасан албан тушаалтны	
				Албан тушаал	Овог нэр
А	1	2	3	4	5
1	Тайлант онд Гаалийн ерөнхий газраас Улаанбаатар хот дахь Гаалийн газарт гадаад худалдааны бараа эргэлт нэмэгдсэнтэй холбогдуулан гаалийн улсын байцаагчийг нэмж ажиллуулан батлагдсан төсөвт орон тоог 15-аар хэтрүүлсэн.	-	Зөвлөмж өгөх	Дарга СААА-ны дарга	Д.Солонго Д.Гантөмөр
	Нийт	-			